



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2007 оны 04 дугаар
сарын 05-ны өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Батлан хамгаалах болон иргэний
хамгаалалтын хууль, тогтоомжуудыг
хэрэгжүүлэх арга хэмжээний тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 9, 15 дугаар зүйлийн 5, Батлан хамгаалах тухай хуулийн 12 дугаар зүйл, Иргэний хамгаалалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 6, 16 дугаар зүйлийн 1-д заасан заалтуудыг үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ НЬ:**

1. Монгол улсын Батлан хамгаалах болон иргэний хамгаалалтын хууль, тогтоомжийн хэрэгжилтийг орон нутагт хангах талаар Засгийн газар, холбогдох төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн агентлагуудаас өгөгдсөн бүх төрлийн дайчилгааны даалгаваруудыг хэрэгжүүлэх, шийдвэр, төлөвлөгөөг байнгын тодотгох, томилгоот бүрэлдэхүүний сургалт, бэлтгэл, бэлэн байдлыг хангуулан, нөөц бүрдэлтийн байдлын талаар сар тутам биечлэн илтгэж байхыг нийслэлийн Засаг даргын дэргэдэх Цэрэг, иргэний хамгаалалтын штаб \Л.Доржсүрэн\ -т даалгасугай.

2. Хөнөөх хэрэгслэлийн хөнөөл, байгалийн болон нийтийг хамарсан гамшиг, ослын аюулаас хүн ам, эд хөрөнгийг урьдчилан сэргийлэх, авран хамгаалах, нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэх, учирсан хор уршгийг арилгах зэрэг иргэний хамгаалалтын арга хэмжээг мэргэжлийн удирдлагаар хангах үүрэг бүхий нийслэлийн Иргэний хамгаалалтын удирдлага, штабын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, Иргэний хамгаалалтын албад тэдгээрийн удирдлагыг хоёрдугаар хавсралтуудаар тус тус баталсугай.

3. Иргэний хамгаалалтын тайван цагийн үндсэн чиг үүрэг болох гамшиг, ослын аюулаас урьдчилан сэргийлэх, авран хамгаалах, хор уршгийг арилгах, сэргээн босгох ажлыг шуурхай зохион байгуулах үүрэгтэйгээр нийслэлийн Байнгын онцгой комисс \Цэргийн аюулын үед дайчилгаа удирдах бүлэг\ -ын бүрэлдэхүүнийг гуравдугаар, ажлын хэсгүүдийг дөрөвдүгээр, дүрмийг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

4. Дээр дурьдсан удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнүүдийг нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэхийн тулд холбогдох албан тушаалтануудад **ДААЛГАХ НЬ:**

а) Цэргийн аюул, хөнөөх хэрэгсэл, гамшиг, ослын үед ажиллах бэлэн байдлын төлөвлөгөөнүүдийг бодитой төлөвлөн хэрэгжүүлэх, тэргүүн ээлжинд үүрэг гүйцэтгэх томилгоот болон мэргэжлийн ангиуд- \нийслэлийн Байгалийн гамшгаас аврах анги\ ийн бүрэлдэхүүнтэй үе шаттай сургалтуудыг зохион байгуулан оногдуулсан үүрэгт нь сургаж дадлагжуулах, цаашид сургалт бэлтгэл, бэлэн байдалд нь байнгын хяналт тавьж, мэргэжлийн удирдлага, заавар, зөвлөмжөөр ханган ажиллах, гамшиг, ослын үед хэрэглэгдэх, хүнс тэжээл, материаллаг хэрэгсэлийн нөөцийг бий болгон хадаглалт, хамгаалалт,

ашиглалтыг хариуцан ажиллахыг нийслэлийн Засаг даргын дэргэдэх Цэрэг,иргэний хамгаалалтын штаб \ Л.Доржсүрэн \-т үүрэг болгосугай.

б\ Нийслэлийн Байнгын онцгой комиссын өдөр тутмын үйл ажиллагаа болон гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, сургалт сурталчилгаа, хяналт шалгалтын ажилд шаардагдах хөрөнгийг оны төсөвт тусгагдсан ёсоор саатуулалгүй санхүүжилт хийж байхыг нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн бодлогын хэлтэс \ Д. Ганболд \-т зөвшөөрсүгэй.

в\ Болзошгүй гамшиг ослын аюулаас үүдэн нийслэлийн үйлдвэр үйлчилгээ, иргэдийн хэвийн амьдрал үйл ажиллагаанд гарч болох сөрөг нөлөө, учирсан хор хөнөөлийг арилгах ажилд дайчлах мэргэжлийн байгууллага, холбогдох албан тушаалтануудыг томилгоожуулан шаардлагатай тоног төхөөрөмж материал хэрэгслэлээр хангах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх, тэдгээрийн бэлтгэл бэлэн байдалд нь байнгын хяналт тавьж ажиллахыг Хотын ерөнхий менежер \ Т.Бадамжунай \-т даалгасугай.

г\ Цэргийн аюул, хөнөөх хэрэгсэл гамшиг ослын аюулын тухай зарлан мэдээлэлт явуулах, авран хамгаалах сэргээн босгох ажлыг шуурхай зохион байгуулалтаар хангах, нийслэлийн ард иргэдийн эрэлт, хүсэлт, санал гомдлыг хүлээн авч холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдэгдэн арга хэмжээ авахуулж, барагдуулах үүрэгтэй нийслэлийн Байнгын онцгой комиссын дэргэдэх "Шуурхай мэдээлэлийн төв"-ийн жижүүрүүдийг өдөр тутмын удирдлагаар ханган, үүрэг гүйцэтгэлтэнд нь хяналт тавьж ажиллахыг нийслэлийн Засаг даргын орлогч \ Сумаахүү \, Хотын Ерөнхий менежер \ Т.Бадамжунай \, Засаг даргын Тамгын газар \ Ц.Болдсайхан \, Цэрэг,иргэний хамгаалалтын штаб \ Л.Доржсүрэн \-т тус тус даалгасугай.

5. Монгол улсын Засгийн газрын 1997 оны 166 дугаар тогтоолын 3-ын 10-т аймаг,нийслэлийн Байнгын онцгой комиссын өдөр тутмын үйл ажиллагааг Цэрэг,иргэний хамгаалалтын штаб эрхэлнэ. Улсын Байнгын онцгой комиссын 2000 оны 17 тоот тогтоолоор аймаг,нийслэлийн Байнгын онцгой комиссын бэлтгэл, бэлэн байдлыг дээшлүүлэх, ажлын зайлшгүй шаардлагыг ханган суудлын авто машин авч албан хэрэгцээнд хэрэглэх тухай заалтуудыг үндэслэн бэлэн байдлын шаардлага хангасан авто машин тогтмол гаргаж байхыг нийслэлийн Засаг даргын дэргэдэх Нийтлэг үйлчилгээний газар \ Т.Дашням \-т үүрэг болгосугай.

6.Нийслэлийн хүн ам, эд хөрөнгийг байгалийн болон нийтийг хамарсан гамшиг ослоос авран хамгаалах, хор уршгийг арилгах ажилд нийслэлийн Цэргийн хүрээний мэргэжлийн анги байгууллагуудын хүч хэрэгсэл, бие бүрэлдэхүүнийг томилгоожуулан, харилцан ажиллах журмыг боловсруулан, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг нийслэлийн Засаг даргын дэргэдэх Цэрэг,иргэний хамгаалалтын штаб \ Л.Доржсүрэн \-т даалгасугай.

7. Энэ захирамж гарсантай холбогдуулан нийслэлийн Засаг даргын 1997 оны " Нийслэлийн иргэдийн аюулгүй байдлыг хангах тухай " а\63 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД

Нийслэлийн Засаг даргын 2001 онь^д тоот захирамжийн 1 дүгээр хавсралт

**НИЙСЛЭЛИЙН ИРГЭНИЙ ХАМГААЛАЛТЫН УДИРДЛАГА,
ШТАБЫН БҮРЭЛДЭХҮҮН**

Нэг. Удирдлага:

- | | | |
|--|--------------|-----------------------------------|
| 1. Нүүлгэн шилжүүлэх асуудал эрхэлсэн орлогч | Ч.Сумаахүү | Нийслэлийн Засаг даргын орлогч |
| 2. Материал хангалт эрхэлсэн орлогч | Т.Бадамжунай | Улаанбаатар хотын Ерөнхий менежер |

Хоёр. Иргэний хамгаалалтын штаб:

- | | | |
|--|--------------|--|
| 1. Дарга | Л.Доржсүрэн | Нийслэлийн Цэрэг, иргэний хамгаалалтын штабын дарга |
| 2. Штабын орлогч, сургалт хариуцсан туслах | Л.Цэрэнсоном | ЦИХШ-ын иргэний хамгаалалтын сургалт эрхэлсэн офицер |

а) Оператив тасаг:

- | | | |
|---|---------------|--|
| 1. Тасгийн дарга, хүч хэрэгсэл хариуцсан туслах | Ч.Бат | НЗДТГ-ын Эдийн засаг, стратегийн бодлогын хэлтсийн дарга |
| 2. Ахлах оператор | Л.Баямбасүрэн | НЗДТГ-ын ТЗУ-ын хэлтсийн зохион байгуулагч |
| 3. Оператор | Ш.Гантөмөр | Статистик мэдээлэл судалгааны албаны мэргэжилтэн |
| 4. Холбоо зарлан мэдээлэл хариуцсан туслах | Л.Батцоож | НЗДТГ-ын ЭЗСБ-ын хэлтсийн мэргэжилтэн |
| 5. Сурталчилгаа хариуцсан туслах | М.Батцэцэг | НЗДТГ-ын ТЗУ-ын хэлтсийн зохион байгуулагч |
| 6. Удирдлагын байрны дарга | Ж.Энхжаргал | Өргөө УҮГ-ын захирал |

б) Хүн ам хамгаалах тасаг:

- | | | |
|--|---------------|--|
| 1. Дарга, инженерийн хамгаалалт хариуцсан туслах | Н.Батэрдэнэ | ЗАА албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн дарга |
| 2. Цацраг хордолт хариуцсан туслах | Х.Нямцэрэн | ЭАХСУАлбаны ажилтан |
| 3. Химийн хордолтоос хамгаалах асуудал эрхэлсэн туслах | С.Зоригсайхан | БОЭХГ-ын ажилтан |
| 4. Нүүлгэн шилжүүлэлт хариуцсан туслах | Ч.Баянчимэг | Статистик мэдээлэл судалгааны албаны дарга |
| 5. ----- х----- | И.Амраа | НЗДТГ-ын ЭЗСБ-ын ажилтан |

21

Нийслэлийн Засаг даргын 2001 оны 04 тоот
захирамжийн 2 дугаар хавсралт

НИЙСЛЭЛИЙН ИРГЭНИЙ ХАМГААЛАЛТЫН АЛБАД

№	Албадын нэр	Түшиглэх байгууллага	Удирдлагын нэр
1	Эмнэлгийн	Эрүүл мэндийн газар	Ц.Ганхүү
2	Хэв журам сахиулах, хөдөлгөөн зохицуулах	Цагдаагийн газар	Н.Ганболд
3	Тээврийн	Тээврийн газар	Ч.Пүрэвдорж
4	Байгаль орчны хяналтын	Байгаль орчин, экологийн хяналтын алба	С.Бүдрагчаа
5	Усаар хангах	Ус сувгын ашиглалтын газар	О.Эрдэнэбаатар
6	Орон сууц нийтийн аж ахуйн	Орон сууц нийтийн аж ахуйн компани	С.Мөнхбаяр
7	Зарлан мэдээллийн	Харилцаа холбоо компаний холбох байгууламжийн алба	М.Алтаночир
8	Гал түймэртэй тэмцэх	Нийслэлийн Гал түймэртэй тэмцэх хэлтэс	Б.Батбаатар

Нийслэлийн Засаг даргын 2001 оны 04 тоот захирамжийн 3 дугаар хавсралт

**НИЙСЛЭЛИЙН БАЙНГЫН ОНЦГОЙ
КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН**

- | | | |
|-------------------------|--------------|---|
| 1. Орлогч | Л. Доржсүрэн | Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Цэрэг, иргэний хамгаалалтын штабын дарга |
| 2. Нарийн бичгийн дарга | Г. Сүхбат | Нийслэлийн Цэрэг, иргэний хамгаалалтын штабын ахлах офицер |

Зөвлөлийн гишүүд:

- | | | |
|----|---------------|--|
| 3. | Ч. Сумаахүү | Нийслэлийн Засаг даргын орлогч |
| 4. | Т. Бадамжунай | Улаанбаатар хотын Ерөнхий менежер |
| 5. | Ц. Болдсайхан | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга |
| 6. | Д. Ганболд | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн бодлогын хэлтсийн дарга |
| 7. | Ц. Ганхүү | Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга |

Гишүүд:

- | | | |
|-----|-----------------|--|
| 8. | Б. Шагдар | Зэвсэгт хүчний Ерөнхий штабын 1 дүгээр орлогч Улаанбаатар хотын Цэргийн хүрээний дарга |
| 9. | Ж. Батболд | Байгалийн голомтот халдварт өвчнөөс эсэргүүэн судлах төвийн захирал |
| 10. | Н. Ганболд | Нийслэлийн Цагдаагийн газрын дарга |
| 11. | Т. Ганбаатар | Замын цагдаагийн газрын хөдөлгөөн хяналтын зохицуулалтын хэлтсийн дарга |
| 12. | Д. Батбаатар | Нийслэлийн гал түймэртэй тэмцэх хэлтсийн дарга |
| 13. | П. Дэлгэрнаран | Өмчийн харилцааны газрын дарга |
| 14. | Г. Бүдрагчаа | Байгаль орчин, экологийн хяналтын газрын дарга |
| 15. | Ё. Цэрэнжаргал | Мал эмнэлэг, хяналтын газрын дарга |
| 16. | Т. Дашням | Нийтлэг үйлчилгээний газрын дарга |
| 17. | О. Эрдэнэбаатар | Ус суваг ашиглалтын газрын дарга |

НИЙСЛЭЛИЙН БАЙНГЫН ОНЦГОЙ КОМИССЫН АЖЛЫН ХЭСГҮҮД

Нэг: Хүч хэрэгслэлийг нэгтгэн удирдах хэсэг

1. Дарга	Ч. Сумаахүү	Нийслэлийн Засаг даргын орлогч
2. НБД	Г.Ганзориг	Нийслэлийн ЦИХШ-ын офицер
3. Гишүүн	Б.Шагдар	УБ цэргийн хүрээний дарга
4. Гишүүн	Н.Ганболд	Нийслэлийн Цагдаагийн газрын дарга
5. Гишүүн	Т.Ганбаатар	Замын цагдаагийн газрын хэлтсийн дарга
6. Гишүүн	Г.Өлзий	Хөрөнгө оруулалтын газрын дарга

Хоёр: Үер, хөлдөлтийн аюулаас сэргийлэх хэсэг

1. Дарга	Т.Бадамжунай	УБ хотын Ерөнхий менежер
2. НБД	Ц.Болд	ЗААлбаны Хот тохижилтийн хэлтсийн дарга
3. Гишүүн	Т.Батэрдэнэ	ЗААлбаны Инженерийн байгууламжийн хэлтсийн дарга
4. Гишүүн	Г.Мөнхбаяр	Нийслэлийн ОСНААКомпаний захирал
5. Гишүүн	О.Эрдэнэбаатар	Нийслэлийн Ус сувгын ашиглалтын газрын дарга

Гурав: Ой хээрийн түймрээс, сэргийлэх хэсэг

1. Дарга	Ц.Болдсайхан	НЗДТГазрын дарга
2. НБД	Д.Батбаатар	Нийслэлийн ГТТ хэлтсийн дарга
3. Гишүүн	Г.Бүдрагчаа	Нийслэлийн БОЭХяналтын газрын дарга
4. Гишүүн	М.Цэлмэг	Хот байгуулалт газрын харилцааны дарга

Дөрөв: Хүн малын гоц халдварт өвчнөөс сэргийлэх хэсэг

1. Дарга	Ц.Ганхүү	Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга
2. НБД	Б.Цэцгээ	Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн
3. Гишүүн	Ё. Цэрэнжаргал	Мал эмнэлгийн хяналтын газрын дарга
3. Гишүүн	Ж.Батболд	БГХӨЭСудлах төвийн захирал

Тав: Үйлдвэрийн осол, химийн хорт бодисын алдагдлаас сэргийлэх хэсэг

1. Дарга	Л.Доржсүрэн	Нийслэлийн ЦИХШтабын дарга
2. НБД	Л.Цэрэнсоном	Нийслэлийн ЦИХШ-ын офицер
3. Гишүүн	П.Дэлгэрнаран	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын дарга
4. Гишүүн	С.Зоригсайхан	Нийслэлийн Байгаль орчин Экологийн хяналтын газрын

Ажлын хэсгүүдэд байх баримт бичгүүд:

1. Урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө
2. Үүсч болох цагийн байдлын нөхцөлд мэргэжлийн хүмүүс, хүч хэрэгслэлийг дайчлан ажилуулах төлөвлөгөө
3. Бусад шаардлагатай гарын авлага, материалууд

24
Нийслэлийн Засаг даргын 2001 оны 04 тоот
захирамжийн 5 дугаар хавсралт

НИЙСЛЭЛИЙН БАЙНГЫН ОНЦГОЙ КОМИССЫН ДҮРЭМ

НЭГ: НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ:

1. Нийслэлийн байнгын онцгой комисс нь байгалийн болон нийтийг хамарсан гамшиг \ цаашид "гамшиг" гэх \ газар хөдлөлт, хүчтэй салхи, ган зуд, үер, ой хээрийн түймэр, цацраг идэвхт болон химийн хорт бодисын хордуулалт, хүн, малын гоц халдварт өвчин зэрэг, үйлдвэрийн томоохон осол \ цаашид "осол" гэх \ үйлдвэр байгууламж, зам тээврийн хэрэгсэлд эвдрэл гарч сүйрэл орох технологийн горим зөрчигдсөнөөс хэвийн үйл ажиллагаа нь алдагдаж аюул учруулах зэрэг бий болж хүний амь нас үрэгдэх эрүүл мэнд хохирох, эд хөрөнгөнд их хэмжээний хохирол учирч аврах ажил гүйцэтгэх шаардлагатай нөхцөл үүсэхэд хүч хэрэгсэл, материалын нөөцийг дайчлан нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэх тэднийг авран хамгаалах, учирсан хор хөнөөлийг арилгах, сэргээн босгох ажил явуулах болон урьдчилан сэргийлэх бололцоотой бүхий л арга хэмжээг Нийслэлийн хэмжээнд удирдан зохион байгуулахад энэ дүрмийг мөрдөнө.

Нийслэлийн Байнгын онцгой комиссын дарга нь нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч байх бөгөөд түүний захирамжаар комиссын бүрэлдэхүүнийг томилон ажиллуулна.

Нийслэлийн Байнгын онцгой комиссын өдөр тутмын ажлын аппарат нь нийслэлийн Засаг даргын дэргэдэх Цэрэг, иргэний хамгаалалтын штаб мөн бөгөөд түүний дарга нь Байнгын онцгой комиссын орлогч дарга байна.

2. Комисс нь Монгол улсын Засгийн газар, Улсын байнгын онцгой комиссын тогтоол, албан даалгавар протокол Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн захирамж, Байнгын онцгой комиссын тогтоол, албан даалгавар, дарга, орлогчийн тушаал болон энэхүү дүрмийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.

3. Комисс нь гамшиг, ослоос урьдчилан сэргийлэхэд болон тохиолдсон үед нэрвэгдэгсдэд туслах авран хамгаалах, учирсан хор хохирлыг арилгах арга хэмжээнд зарцуулах хөрөнгө санхүүгийн бэлтгэл сантай байна. Уг хөрөнгийг захиран зарцуулах эрх зүйн акт нь комиссын дарга, орлогчийн тушаал байна.

4. Комисс нь дүүргүүдийн байнгын онцгой комиссыг удирдлагаар хангаж ажлаа Улсын онцгой комисст тайлагнана.

5. Комисс нь гамшиг, осол тохиолдсон үед нэрвэгдэгсдэд үзүүлэх тусламж, тэднийг авран хамгаалах, учирсан хор уршгийг арилгах ажлыг нутаг дэвсгэрт нь байрлаж үйл ажиллагаагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагыг түшиглэн зохион байгуулна.

6. Комисс үүрэг зорилтоо хэрэгжүүлэхдээ холбогдсон асуудлыг Монгол улсын хууль тогтоомжинд нийцүүлэн Зөвлөлийн гишүүдийн хурлаар хэлэлцэж өөрийн эрх хэмжээний хүрээнд Нийслэлийн Байнгын онцгой комиссын тогтоол, албан даалгавар, протокол, комиссын дарга, орлогчийн тушаал гаргана.

7. Комисс нь тогтоосон журмаар хийлгэсэн тамга, тэмдэг албан бичгийн хэвлэмэл хуудас, гишүүний үнэмлэхтэй байна.

ХОЁР. КОМИССЫН ҮҮРЭГ:

а) Нийслэлийн хэмжээнд тохиолдож болзошгүй гамшиг осол түүнээс учирч болох хор хөнөөлийг арилгах, нэрвэгдэгсдийг авран хамгаалах, сэргээн босгоход шаардагдах хүч хэрэгслэлийг урьдчилан нарийн тооцсон үндэслэлтэй төлөвлөгөө боловсруулан, Нийслэлийн Иргэний хамгаалалтын даргаар батлуулж байнга тодотгон, шаардлагатай үед үүрэг гүйцэтгэх, сургалт бэлтгэл бэлэн байдлыг хангуулах,

б) Гамшиг осол тохиолдсон үед мэргэжлийн холбогдох байгууллага, албан тушаалтнуудтай хамтран тухайн нөхцөл байдалд үнэлэлт өгч нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэх тэднийг аврах хамгаалах, учирсан хор уршгийг арилгах ажлыг зохих хууль тогтоомжийн дагуу шуурхай зохион байгуулах,

в) Гамшиг ослын үед шуурхай гарч үүрэг гүйцэтгэх хүч хэрэгслэлийн байршил, бүрэлдэхүүний хангалт, бэлэн байдлыг байнга хяналтандаа байлгаж, тэдгээрт зарлан мэдээлэлт хүргэх найдвартай арга хэмжээг холбогдох байгууллагаар дамжуулан хэрэгжүүлж, явцад нь хяналт тавина. Нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэх тэднийг аврах хамгаалах, учирсан хор уршгийг арилгахад шаардагдах техник, хүн хүч тээвэр холбооны хэрэгсэл, шатахуун, эд хөрөнгийг зохих хууль тогтоомжийн дагуу дайчлан гаргах асуудлыг холбогдох газарт тавьж шийдвэрлэнэ.

г) Гамшиг, ослын үед дайчлан ажиллуулахаар төлөвлөгдсөн хүч хэрэгслэлийн бэлэн байдлыг шалгаж шаардлагатай арга хэмжээг авахуулах,

д) Гамшиг, осол тохиолдсон нийслэлийн дэвсгэр нутаг, аж ахуйн нэгж байгууллагад онцгой дэглэм, хорио цээр тогтоох асуудлыг зохих хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлж, мөрдүүлэх ажлыг зохион байгуулах,

е) Гамшиг ослын холбогдолтой асуудлаар эрх хэмжээнийхээ хүрээнд зохих хууль тогтоомжийн дагуу, нутаг дэвсгэрийн төр засаг, аж ахуйн нэгж байгууллагын эрх баригч нартай хамтран ажиллах урьдчилан сэргийлэх арга хэмжээнд татан оролцуулах

и) Гамшиг ослоос сэргийлэх нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэх тэднийг аврах хамгаалах талаар гарсан хууль тогтоомжоор сургалт сурталчилгааг жил улирлаар төлөвлөн зохион байгуулах,

н) Гамшиг ослын голомтод ажиллагсдын ажиллах журмыг тухайн нөхцөл байдалтай уялдуулан тогтоон өгч хэрэгжилтийн явцад хяналт тавих,

з) Улсын онцгой комиссын заавар, шийдвэрийг хэрэгжүүлэх үр дүнг Улсын онцгой комисст тогтоосон журмын дагуу мэдээлэн тайлагнана.

ГУРАВ. КОМИССЫН ЭРХ

а) Гамшиг ослоос сэргийлэх ажлыг зохион байгуулах, тэдгээрийн хор уршгийг арилгахтай холбогдсон асуудлаар Нийслэлийн нутаг дэвсгэр дээр байрлаж үйл ажиллагаа явуулж байгаа төр захиргааны болон аж ахуйн нэгж байгууллагын эрх баригчдад үүрэг даалгавар өгөх шаардлага тавих,

б) Гамшиг осол тохиолдсон нийслэлийн нутаг дэвсгэрийн хэсэг байгууламжид онцгой дэглэм хорио тогтоож мөрдүүлэхтэй холбогдсон журам гаргаж хэрэгжилтэд хяналт тавих шаардлагатай тохиолдолд тэдгээрийг хамгаалалтанд авахуулах асуудлыг шийдвэрлэх,

в) Гамшиг ослоос сэргийлэх, хор уршгийг арилгах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ зохион байгуулсан ажлын талаар холбогдох байгууллагын эрх баригчдын мэдээлэл илтгэлийг хэлэлцэж шийдвэр гаргаж чиглэл өгөх,

г) Гамшиг осолд нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэх тэднийг аврах хамгаалах учирсан хор уршгийг арилгах ажилд шаардагдах техник тоног төхөөрөмж шатахуун, эм хүнсний болон бусад бараа материалыг нийслэлийн нөөцөөс гаргуулах, хөрөнгө зардал олгох тухай асуудлыг хууль тогтоомжийн дагуу Нийслэлийн Засаг даргын зөвлөлд оруулж шийдвэрлүүлэх,

д) Ард иргэд томилогдсон хүч хэрэгсэл /мэргэжлийн байгууллага/-тай гамшиг ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор сургалт сурталчилгаа хяналт шалгалтын ажил явуулах тэдгээрийн бэлэн байдлыг хангуулах бичиг хэргийн болон шагнал урамшил зэрэг шаардагдах хөрөнгийг комиссын шийдвэрээр бэлтгэл сангаас гарган захиран зарцуулах,

е) Гамшиг осол тохиолдсон үед нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэх тэднийг аврах хамгаалах гамшиг ослын шалтгааныг тодруулах учирсан хор хохирлын уршиг, үр дагварыг арилгах ажилд мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулах тэднээр шаардагдах судалгаа дүгнэлт материал гаргуулан авах,

и) Гамшиг осол тохиолдсон газар дээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг тухайн нөхцөл байдалтай уялдуулан зохих хууль тогтоомжийн дагуу боловсронгуй болгон тодотгох, зохицуулах үүнтэй уялдуулан гаргах бусад асуудлыг шийдвэрлэх,

ж) Гамшиг осол гарсан дэвсгэр нутаг, байгууламжид авран хамгаалах ажлыг нэн яаралтай зохион байгуулахаар Нийслэлийн Байнгын онцгой комиссын гишүүд Замын цагдаагийн байгууллагын ажилтанд мэдэгдэж тээврийн хэрэгслэлийг түр дайчлан гаргуулж төлбөрийг гүйцэтгэлээр нь тооцоо хийх,

з) Гамшиг осолд нэрвэгдэгсдэд эмнэлэгийн тусламж үзүүлэх, хор уршгийг арилгах зорилгоор техник, холбооны хэрэгсэл, хүн хүч бусад материалыг дайчлан гаргуулах, сууц багаж хэрэгсэл бэгдүүлэх,

ДӨРӨВ. КОМИССЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЧИМ

а) Комиссын үүрэг зорилтоо хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн зарчим нь нэгэн удирдлага мөн.

б) Комисс нь аливаа асуудлыг Зөвлөлийн гишүүдийнхээ хурлаар хэлэлцэж эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэрлэх бөгөөд Зөвлөл нь дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга, ажлын хэсгүүдийн ахлагч нараас бүрдэнэ.

в) Комисс нь цаг улирлын болон тодорхой нөхцөл байдалд тохиолдож болох гамшиг ослоос урьдчилан сэргийлэх тохиолдсон үед нэрвэгдэгсдэд анхны тусламж яаралтай үзүүлж чадах зохих бэлтгэлтэй ажлын хэсгүүдээс бүрдэнэ. Шаардлагатай гэж үзвэл ажлын хэсгийг нэмж байгуулах, бүрэлдэхүүнд мэргэжлийн хүмүүсийг түр хугацаагаар оруулан ажиллуулах асуудлыг тухайн нөхцөл байдалтай уялдуулан комисс шийдвэрлэж болно.

᠒᠒

᠒\ Комисс нь ажлаа жил улирлаар дүгнэх бөгөөд баримт бичиг нь тухайн ажлын хэсгүүдийн нарийн бичгийн дарга дээр хадгалагдана. Ажлын хэсгийн нарийн бичгийн даргын үүргийг тухайн салбар хариуцсан Засаг даргын Тамгын газрын болон дэргэдэх газар, хэлтсийн мэргэжилтэн \ зохион байгуулагч \ байна.

ТАВ. ДҮҮРГИЙН БАЙНГЫН ОНЦГОЙ КОМИСС

а\ Комиссын дүүргийн Засаг даргын шийдвэрээр байгуулах бөгөөд комиссын өдөр тутмын үйл ажиллагааг дүүргийн Цэрэг , иргэний хамгаалалтын штаб эрхлэнэ.

б\ Комисс нь гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэх тэднийг аврах хамгаалах, учирсан хор хохирлыг арилгах арга хэмжээг нутаг дэвсгэртээ зохион байгуулж энэ талаар гарсан хууль тогтоомж тушаал албан даалгаврын биелэлтэд хяналт тавих, нийслэлийн комиссын заавар хэрэгжүүлэх үүрэгтэй ажиллана. Дүүрэгт гамшиг ослоос сэргийлэх, түүний хор уршгийг шуурхай арилгах асуудлыг тухайн дүүргийн Засаг дарга \ комиссын дарга \ шууд хариуцна.

в\ Комисс нь энэ дүрмийн 2, 3 дугаар бүлэгт заасан Нийслэлийн байнгын онцгой комиссын эрх үүргээс эрх хэмжээндээ хамаарах хэсгийг нутаг дэвсгэртээ хэрэгжүүлнэ.

г\ Комисс нь гамшиг ослоос сэргийлэх хамгаалах тэдгээрийн хор уршгийг арилгах талаар авч байгаа арга хэмжээ явц үр дүнг Нийслэлийн Байнгын онцгой комисст тогтоосон журмын дагуу мэдээлж тайлагнана.

ЗУРГАА. КОМИССЫН ХӨРӨНГӨ, ТҮҮНИЙГ ЗАХИРАН ЗАРЦУУЛАХ

1. Комисс нь өөрийн мэдлийн хөрөнгө, санхүүгийн эх үүсвэртэй байна. Комиссын хөрөнгө санхүү нь тухайн жил орон нутгаас батлагдсан төсөв, гамшиг, ослын үед хор уршгийг арилгах тохиолдолд Засаг даргын шийдвэрээр орон нутгийн төсвөөс шилжүүлсэн мөнгө, хөрөнгө, Гадаад орон, олон улсын байгууллага, иргэд, түүнчилэн өөрийн орны байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламжаас бүрдэнэ.

2. Комисс нь хандив, тусламжаар төвлөрсөн болон өөрийн мэдлийн хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр, бэлтгэл сангийн хөрөнгийг нэг дансанд төвлөрүүлэн, зориулалтын дагуу захиран зарцуулах эрх эдэлнэ.

3. Комиссын мэдлийн хөрөнгийг олгогдсон эрх хэмжээнийхээ дагуу, дарга, орлогч нар захиран зарцуулах эрх эдэлнэ.

4. Комиссын мэдлийн хөрөнгө, сангийн ашиглалт, зарцуулалтын байдлыг зохих журмын дагуу нягтлан бодох бүртгэлд тусган хагас, бүтэн жилээр баланс гаргана.

5. Комисс нь үйл ажиллагааныхаа тайлан, хөрөнгө санхүүгийн балансаа жил бүр хурлаараа хэлэлцэж, холбогдох байгууллагад танилцуулж байна.